



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 4/329

Мандалговь

Газар эзэмших эрх
дуусгавар болгох тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт /Төв халхын дуулалт, жүжгийн театрын баруун талд, 30 айлын орон сууцны зүүн талд/ байршилтай Би Эй Ди Ай ХХК /5083362/ -ын 360м^2 /0.036 га/ газар дээр 16 айлын нийтийн орон сууц барьсан тул, газар эзэмших эрхийг дуусгавар болгож нийтийн эдэлбэрийн газар болгосугай.

Хоёр. Дээрх ААН-ийн газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2012 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/347 дугаар захирамж мөн газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

408010053